

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2017 оны 12 дугаар сарын 15

№

Улаанбаатар хот

2017 12 18 16 9

Энэхүү ажил гүйцэтгэх гэрээ /цаашид "Гэрээ" гэх /-г

Нэг талаас: Эрүүл мэндийн хөгжлийн төв /цаашид "Захиалагч" гэх/

Нөгөө талаас: Иргэн Гунгаажавын Цэцэнсанаа нар харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү гэрээ нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтээр, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захиалгын дагуу Эрүүл мэндийн сайд, Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн сайдын хамтран баталсан А/191, А/64 дугаар тушаал "Нянгийн тэсвэржилтээс сэргийлэх салбар дундын хамтын ажиллагааны төлөвлөгөө 2017 - 2020"-ний 5.2-т "Хүний болон малын эмнэлгийн нянгийн эсрэг эмийн хэрэглээг судлах аргачлал боловсруулах", 5.3-д "Хүн болон малын эмнэлгийн салбар дахь нянгийн эсрэг эмийн хэрэглээний судалгаа хийх" гэж заасны дагуу "Нянгийн эсрэг эмийн хэрэглээг тодорхойлох" ажлыг хийж гүйцэтгэхэд талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлоход оршино.

1.2 Гэрээнд зааснаас бусад нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд талууд харилцан тохиролцож бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

2.1 Ажил гүйцэтгэгч нь энэхүү гэрээний 1.1-д заасан ажлыг 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэнэ.

ГУРАВ. АЖЛЫН ХӨЛС

3.1 Гэрээт ажлын хүрээнд нянгийн эсрэг эмийн тайланг хянах ажлын хөлсийг 200,000₮ /хоёр зуун мянган төгрөг/-өөр тогтов.

ДӨРӨВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

4.1. Захиалагч нь гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийн тайланг 2017 оны 01 дугаар сарын 23-ны дотор хүлээн авч, дүгнэнэ.

4.2. "Нянгийн эсрэг эмийн хэрэглээг тодорхойлох" ажлыг үр дүнтэй, гэрээт хугацаанд гүйцэтгэхийг шаардах.

4.3. Гэрээт ажлын хөлсийг Худалдаа хөгжлийн банкны Г.Цэцэнсанаа эзэмшигчтэй 495038458 дугаарын данс руу 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор шилжүүлнэ.

ТАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

- 5.1 Гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэнэ.
- 5.2 Нянгийн эсрэг эмийн хэрэглээг тодорхойлох ажлыг чанартай, үр дүнтэй гүйцэтгэнэ.

ЗУРГАА. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- 6.1 Гэрээний үүрэг хэрэгжих явцад Талуудын хамтын ажиллагааны ёс зүйг эрхэмлэн байгууллагын нэр хүнд болон түүнд хамаарах бусад үнэт зүйлсийг хүндэтгэж ажиллана.
- 6.2 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй.
- 6.3 Гэрээг 2 хувь үйлдэж “захиалагч” тал нэг хувийг “гүйцэтгэгч” тал нэг хувийг тус тус хадгална.

ДОЛОО. БУСАД ЗҮЙЛ


- 7.1 Ажил гүйцэтгэх явцад гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Эрүүл мэндийн хөгжлийн
төвийн ерөнхий захирлын
албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч

Б.Нарантуяа



ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Иргэн  Г.Цэцэнсанаа

/РД:ЧЖ75080567/